



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/20

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ-2020" хөтөлбөрийн 3.5.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Бид нэг гэр бүл" шилдэг анги, хамт олон шалгаруулах уралдааны тэргүүн байранд шалгарсан сурагчдын Найрамдал зусланд амрах замын зардалд 2620000 (хоёр сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 2620000 (хоёр сая зургаан зуун хорин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100184